



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

“Төрийн аудитын байгууллагын шагнал олгох журам”-ыг шинэчлэн батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 29.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн аудитын байгууллагын шагнал олгох журам”-ыг 1 дүгээр, “Төрийн аудитын байгууллагын шагналаар шагнуулах албан хаагч, ажилтны анкет”-ийн загварыг 2 дугаар, “Төрийн хяналтын тэргүүний ажилтан тэмдэг”-ний үнэмлэхийн загварыг 3 дугаар, “Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ийн загварыг 4 дүгээр, Монгол Улсын Аудитын дээд байгууллагын “Хүндэт медаль”-ийг 5 дугаар, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Өргөмжлөл”-ийг 6 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн баталсан журмыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Төрийн аудитын байгууллагын шагналын журмыг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/235 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Цэрэнлхам)-т даалгасугай.



Д.ЗАНДАНБАТ



## ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд хуулиар хүлээсэн үүргээ үнэнч, шударгаар биелүүлж, төрийн хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд оруулсан хувь, нэмрийг үнэлж төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагч, ажилтныг Төрийн аудитын байгууллагын шагналд тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Төрийн аудитын байгууллагын шагналын зорилго нь төрийн хяналт, аудитын чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагч, ажилтны ажлын амжилтыг үнэлж, урамшуулах, тэдний идэвх санаачилгыг дэмжихэд оршино.

1.3. Төрийн аудитын байгууллагын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

- 1.3.1. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдэг;
- 1.3.2. Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг";
- 1.3.3. Монгол Улсын Аудитын дээд байгууллагын "Хүндэт медаль";
- 1.3.4. Монгол Улсын Ерөнхий аудиторовын "Өргөмжлөл".

1.4. Төрийн аудитын байгууллагын шагналыг "Үндэсний их баяр наадам", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсэн баяр" төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын тэгш ой, төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын болон Санхүү, эдийн засагчдын өдрөөр тус тус олгоно.

1.5. Төрийн аудитын байгууллагын шагналаар шагнуулах албан хаагч, ажилтны тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг журмын 1.4-т заасан тэмдэглэлт өдрөөс 30 хоногийн өмнө Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### Хоёр. Шагнал олгох болзол

2.1. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон албан хаагч, ажилтан нь дор дурдсан болзлыг хангасан байна.

2.1.1. Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалд 15 болон түүнээс дээш жил ажилласан байх;

2.1.2. Ажил, мэргэжлээрээ хамт олноо манлайлж ажлын амжилт гаргасан, Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ сүүлийн 3 жил "А", "В" үнэлэгдсэн байх, Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг хувийн аудитын компанийн ажилтны сүүлийн 3 жилийн ажлын үр дүн тодорхой гарсан байх;

2.1.3. Төрийн хяналтын байгууллагын бодлого, шийдвэр, чиг үүргийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж, ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэлэг арга барил, дэвшилтэд үйл ажиллагаа нэвтрүүлсэн байх;

2.1.4.Төрийн хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх.

2.2.Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ээр шагнуулахаар тодорхойлсон албан хаагч, ажилтан нь дор дурдсан болзлыг хангасан байна.

2.2.1. Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагад 5 болон түүнээс дээш жил ажилласан байх;

2.2.2.Ажил, мэргэжлээрээ хамт олноо манлайлж, ажлын амжилт гаргасан, Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ сүүлийн 2 жил “А”, “В”үнэлэгдсэн байх, Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг хувийн аудитын компанийн ажилтны сүүлийн 2 жилийн ажлын үр дүн тодорхой гарсан байх;

2.2.3.Төрийн хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх.

2.3.Монгол Улсын Аудитын дээд байгууллагын “Хүндэт тэмдэг”-ээр шагнах гадаадын болон дотоодын иргэн нь дор дурдсан болзлыг хангасан байна.

2.3.1.Төрийн аудитын байгууллагын гишүүнчлэлтэй Аудитын дээд байгууллагуудын олон улсын төрөлжсөн байгууллагууд, эсхүл түүний гишүүн орнуудын аудитын байгууллагын албан хаагчаар ажилладаг, хоёр байгууллагын түншлэл, харилцаа, хамтын ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан байх.

2.4. Монгол Улсын Ерөнхий аудиторын “Өргөмжлөл”-өөр шагнуулах иргэн дор дурдсан болзлыг хангасан байна.

2.4.1.Төрийн аудитын байгууллагын харилцагч байгууллагын албан хаагчаар ажилладаг, хоёр байгууллагын хамтын ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан байх.

### **Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох**

3.1. Энэ журмын 2.1, 2.2, 2.3, 2.4-т заасан болзлыг хангасан албан хаагч, ажилтны тодорхойлолтыг дараах байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилна.

3.1.1.Үндэсний аудитын газрын Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын даргыг Тамгын дарга;

3.1.2.Үндэсний аудитын газрын албан хаагчийг шууд харьяалан удирдах нэгжийн захирал (дарга);

3.1.3.Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын албан хаагчийг тухайн газрын дарга, тэргүүлэх аудитор;

3.1.4.Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагын албан хаагчийг тухайн байгууллагын дарга;

3.1.5.Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг аж ахуйн нэгж байгууллагын ажилтныг тухайн байгууллагын захирал (ҮАГ-ын холбогдох зохион байгуулалтын нэгжийн даргын санал авсан байна);

3.2. Албан хаагч, ажилтныг төрийн аудитын байгууллагын шагналд тодорхойлохдоо хамт олны эсхүл удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж нэр дэвшүүлэн, хурлын тэмдэглэл хөтөлнө.

3.3. Шагнуулахаар ирүүлсэн албан хаагч, ажилтны ажил байдлын тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг Захиргаа, удирдлагын газар хянаж, байгууллагын “Шагнуулах асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын

хэсэг"-ээр хэлэлцүүлсэн саналыг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна. Монгол Улсын Ерөнхий аудитор "Шагнах тухай" шийдвэр гаргана.

3.4. Шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, бичиг баримтыг хадгаламжийн нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд шилжүүлнэ.

#### **Дөрөв. Шагнуулах албан хаагч, ажилтны баримт бичгийн бүрдэл**

4.1. Шагнуулах тухай байгууллагын даргын хүсэлт (албан тоот);

4.2. Албан хаагч, ажилтны ажил байдлын тодорхойлолт;

4.3. Төрийн хяналтын байгууллагын албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг аж ахуйн нэгж байгууллагыг ажилтны ажлын үр дүн, үнэлгээ (Журмын 2.1.2, 2.3.2 дахь хэсэгт заасны дагуу)

4.4. Журмын хавсралтаар баталсан "Анкет"-ыг үнэн зөв бөглөсөн байх;

4.5. Хамт оны эсхүл Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл;

4.6. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх бичиг баримт, шийдвэрийн хуулбар.

#### **Тав. Тэмдэг, үнэмлэх, хүндэт жуух бичиг нөхөн олгох**

5.1. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан тэмдэг", түүний үнэмлэх, "Хүндэт жуух бичиг" үрэгдүүлсний улмаас нөхөн авах хүсэлтийг дор дурдсан баримт бичгийг хамт Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

5.1.1. Албан хаагч, ажилтан, иргэний хүсэлт;

5.1.2. Иргэний үнэмлэхний хуулбар;

5.1.3. Шагналын асуудал хариуцсан албан хаагч өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан үзэж, "Төрийн хяналтын тэргүүний ажилтан тэмдэг", үнэмлэх, "Хүндэт жуух бичиг"-ийг нөхөн олгох үндэслэлтэй гэж үзвэл нөхөн олгуулах саналыг "Шагнуулах асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-т танилцуулж, Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр олгоно.

#### **Зургаа. Шагналын мэдээллийн сан**

6.1. Үндэсний аудитын газар нь шагнагдсан албан хаагч, ажилтны мэдээллийг агуулсан цахим сантай байна.

6.2. Шагналын санг хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч (*Шагналын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга*) хөтөлж, баяжуулна.

6.3. Монгол Улсын цол, төрийн дээд шагнал, одон медаль, салбарын болон төрийн аудитын байгууллагын шагналаар шагнагдсан албан хаагчийн мэдээллийг шагналын санд тухай бүр бүртгэж, албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэн хадгална.

#### **Долоо. Бусад**

7.1. Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг"-ээр шагнуулснаас хойш 3 ба түүнээс дээш жил ажилласан, "Төрийн аудитын байгууллагын шагнал олгох

журам"-д заасан болзлыг хангасан албан хаагч, ажилтныг "Төрийн хяналтын тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнуулахаар нэр дэвшүүлнэ.

7.2.Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд онцгой чухал, онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн албан хаагч, ажилтныг энэ журамд заасан болзол хангасан эсэхийг үл харгалзан Төрийн албаны тухай хуульд заасны дагуу "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдэг, Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг"-ээр, Төрийн аудитын байгууллагын гишүүнчлэлтэй Аудитын дээд байгууллагуудын олон улсын төрөлжсөн байгууллагууд, эсхүл түүний гишүүн орны аудитын байгууллагын албан хаагч, иргэнийг хоёр байгууллагын түншлэл, харилцаа, хамтын ажиллагаанд оруулсан хувь нэмрийг үнэлж "Монгол Улсын Аудитын дээд байгууллагын "Хүндэт медаль"-аар, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан харилцагч байгууллагын албан хаагчийг Монгол Улсын Ерөнхий аудиторын "Өргөмжлөл"-өөр шагнах асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудиторын санаачилгаар шийдвэрлэж болно.

7.3.Төрийн хяналтын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнийг төрийн аудитын байгууллагын шагналаар шагнуулах саналыг ажиллаж байсан байгууллагын дарга Монгол Улсын Ерөнхий аудиторт ирүүлж болно.

7.4.Энэхүү журамд заасан болзол, баримт бичгийн шаардлага хангаагүй албан хаагч, ажилтныг төрийн аудитын байгууллагын шагналаар шагнахыг хориглоно.

7.5."Төрийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдэг, Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг", "Монгол Улсын Аудитын дээд байгууллагын "Хүндэт медаль", Монгол Улсын Ерөнхий аудиторын "Өргөмжлөл"-ээр албан хаагч, иргэнийг нэг удаа шагнана.

7.6."Төрийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдгийн үнэмлэх, "Хүндэт жуух бичиг"-т Монгол Улсын Ерөнхий аудитор гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

7.7. "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдгийн үнэмлэх, Төрийн аудитын байгууллагын "Хүндэт жуух бичиг", Аудитын дээд байгууллагын "Хүндэт медаль", Монгол Улсын Ерөнхий аудиторын "Өргөмжлөл" нь тус тусын хувийн дугаартай байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын  
2022 оны 03 дугаар сарын 30 -ны өдрийн  
А/ЗО дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛААР  
ШАГНУУЛАХ АЛБАН ХААГЧ, АЖИЛТНЫ АНКЕТ

1. Ургийн овог
2. Эцэг (эх)-ийн нэр
3. Өөрийн нэр
4. Хүйс
5. Боловсрол, мэргэжил
6. Регистрийн дугаар
7. Үндсэн захиргаа
8. Одоо эрхэлж буй байгууллага, албан тушаал
9. Ажлын туршлага

№	Байгууллага, нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Ажилд орсон, ажлаас гарсан огноо
Улсад ажилласан жил			
Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалд ажилласан жил			


10. Төр, Засгийн болон салбарын тэргүүн, төрийн аудитын байгууллагын шагналын талаарх мэдээлэл

№	Шагналын нэр	Шагнал олгосон зарлиг, захирамж, тушаалын нэр, он, сар, өдөр, дугаар

11. Шагнуулах үндэслэл:  
.....  
.....  
.....  
.....

12. Шагнуулах тухай байгууллага, хамт олны саналын хувь:

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА (Захирал)-ЫН  
ГАРЫН ҮСЭГ (.....)



“ТӨРИЙН ХЯНАЛТЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ТЭМДЭГ”- ИЙН  
ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

А. Дотор тал


<p style="text-align: center;">ТЭМДЭГ</p> <p style="text-align: center;">Дугаар _____</p> <p>20 ____ оны ____ -р сарын ____ -ны өдөр</p>	<p>Хүндэт _____ танаа</p> <p>Монгол Улсад төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасныг тань үнэлж, “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” тэмдгээр шагнав.</p> <p>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР (.....)</p>
--	---


Б. Гадна тал

	<p>Үнэмлэхний хавтас хүрэн улаан өнгөтэй байна</p>
---	--



**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН “ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ”-ИЙН ЗАГВАР**

<p>Дотор талд</p>  <p><b>ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ</b> Дугаар _____</p> <p>20 ____ оны ____ -р сарын ____ -ны өдөр</p>	<p>Хүндэт _____ танаа</p> <p>Монгол Улсад төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасныг тань үнэлж, Төрийн аудитын байгууллагын “ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ” - ээр шагнав.</p> <p><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР</b> (.....)</p>
---	--





Монгол Улсын Ерөнхий аудиторын  
2022 оны 03 дугаар сарын 30 ны өдрийн  
А/30 дугаар тушаалын 5 дугаар хэвсрэлт



**МОНГОЛ УЛСЫН АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН  
“ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИЙН ЗАГВАР**



Монгол Улсын Ерөнхий аудиторын  
2022 оны 03 дугаар сарын 30 ны өдрийн  
А/ЗО дугаар тушаалын 6 дугаар хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
“ӨРГӨМЖЛӨЛ”- ИЙН ЗАГВАР**

